



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/09

Бор-өндөр сум

**Эрсдэлээс сэргийлэх хяналтын багийг
шинэчлэн томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай А/566 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэгдсэн эмнэлгийн “Эрсдэлээс сэргийлэх хяналтын баг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Э.Гантулга	Мэс заслын эмч
Нарийн бичиг:	Б.Мөнхтунгалаг	Уламжлалтын сувилагч
Гишүүд:	М.Цэцэгмаа	Эх баригч

2. Эмнэлэгт учирч буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах зэрэг олон талт үйл ажиллагааг тусган төлөвлөгөө боловсруулан, байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллахыг эрсдэлээс сэргийлэх хяналтын багт даалгасугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны 05 дугар сарын 04-ний өдрийн “Эрсдэлээс сэргийлэх хяналтын ажилтан томилох тухай” А/12 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд арга зүйн зөвлөгөө өгч, хамтарч ажиллахыг Үйл ажиллагааны дарга (Т.Баярчимэг)-т даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

